- *Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд сумынхаа эдийн засаг, нийгмийн хөгжлийг эрчимжүүлж, байгаль орчин, бизнест ээлтэй ногоон хөгжлийн бодлого хэрэгжүүлэх*
- *Төрийн үйлчилгээг чанарын шинэ шатанд гаргаж, ард иргэдийнхээ амьдрах орчныг сайжруулах, аж амьдралыг дээшлүүлэх олон талт үйл ажиллагаа явуулах*

## НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Жаргалант сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор Төр, захиргааны байгууллагын дотоод хяналт болон бусад хяналтын байгууллагууд 2020 онд тус байгууллагад хяналт хэрэгжүүлээгүй Санхүү, дотоод аудитын газраас 2018-2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хийж цалин хөлстэй холбоотой 4302.3 мянган төгрөгийн төлбөрийн акт, дотоод хяналттай холбоотой 15211.0 мянган төгрөгийн албан шаардлага өгсөн байна.

Сумын Төрийн сангаас өдөр тутмын санхүүгийн гүйлгээнд дотоод хяналт хэрэгжүүлсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаа, санхүүд хэрэгжүүлсэн дотоод хяналтын тайлан мэдээ байхгүй байна.

Жаргалант сумын ТТЗ-ын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд ‘’Дунд’’ гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад үр нөлөөтэй гэж үзлээ.

## 3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшнийг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Энэ нь материаллаг байдлыг үнэ цэнэ талаас нь авч үзэхийн тулд санхүүгийн тайлангийн хамгийн чухал хэсгүүд болох нийт орлогыг /өөрийн орлого, төсвийн санхүүжилт, татвар болон татварын бус орлого / сонгон авч үзлээ.

Төлөвлөлтийн үе шатанд 2019 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлангаас тооцсон бол гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн нийт орлого 32316535.6 мянган төгрөгөөс 1 хувиар тооцож 323165.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон болно.

## 3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 402405.1 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 393059.2 мянган төгрөг болж 9345.9 мянган төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №1 Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Төрийн сан | 370,808.4 | 345,199.7 | (25,608.7) |
| ОНХС | 29,126.9 | 32,845.7 | 3,718.8 |
| СХС | 2,469.8 | 15,013.8 | 12,544.0 |
| Нийт | 402,405.1 | 393,059.2 | (9,345.9) |

*Эх сурвалж: Жаргалант сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайла*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 393059.2 мянган төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд байршиж байгаа бөгөөд арилжааны банканд харилцах данс байхгүй байна.

### 3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 1430735.1 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 1312437.8 мянган төгрөг болж 118297.3 мянган төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №.2. Авлагын үлдэгдэл /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Ажиллагчидтай холбогдсон авлага | 18,535.7 | 17,705.8 | (829.9) |
| Төлбөртэй үйлчилгээний авлага | 1,678.0 | 1,678.0 | - |
| Зээлийн хүүгийн авлага | 44,144.1 | 62,571.5 | 18,427.4 |
| Байгууллагаас авах авлага | 278,086.9 | 139,748.1 | (138,338.8) |
| Хувь хүмүүсээс авах авлага | 18,264.8 | 29,365.8 | 11,101.0 |
| Урьдчилж гарсан зардлын авлага | 52,707.7 | 47,336.5 | (5,371.2) |
| Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага | 1,017,317.9 | 1,014,032.1 | (3,285.8) |
| Дүн | 1,430,735.1 | 1,312,437.8 | (118,297.3) |

*Эх сурвалж: Жаргалант сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай сум хөгжүүлэх сангийн 586199.5 мянган төгрөг, хугацаандаа байгаа болон бусад 677223.8 мянган төгрөгийн авлага, урьдчилж гарсан зардлын авлага 47336.5 мянган төгрөг, төлбөртэй үйлчилгээний 1678.0 мянган төгрөгийн авлагууд байна.

*Сум хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн авлага оны эхэнд 1017317.9 мянган төгрөг оны эцэст 1014032.1 мянган төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй байна. Тайлант онд зээлийн эргэн төлөлтөөс 200000.0 мянган төгрөг, өмнөх оны үлдэгдлээс 2469.8 мянган төгрөг нийт 202469.8 мянган төгрөгийн зээлийн эх үүсвэр баталснаас үндсэн зээлийн эргэн төлөлтөөс 121285.8 мянган төгрөг, хүүгийн орлого 8662.0 мянган төгрөг, хүү алданги 2288.2 мянган төгрөг нийт 132236.0 мянган төгрөгийн зээлийн орлого бүрдүүлж 67764.0 мянган төгрөгөөр орлогын эх үүсвэрийг дутуу бүрдүүлсэн байна. Тайлант онд 118000.0 мянган төгрөгийн зээл олгож, хяналтын зардалд 1692.0 мянган төгрөг буюу 119692.0 мянган төгрөг зарцуулж оны эцэст 15013.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.*

*Сум хөгжүүлэх сангаас 2017-2019 онуудад олгосон 88 иргэний 379401.5 мянган төгрөгийн зээлийн авлага нь хэвийн төлөгдөж, 2011-2016 онуудад олгосон 98 иргэнтэй*

*холбогдох 721567.8 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн авлага сангийн эргэцийг удаашруулж, хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна. Тухайн хугацаа хэтэрсэн 98 иргэнээс 14 иргэнтэй холбогдох 118670.0 мянган төгрөгийн авлагыг 2020 оны 1 дүгээр сард шүүх, хяналтын байгууллагад шилжүүлсэн байна. СХС-ийн 16698.3 мянган төгрөгийн зээлтэй 5 иргэн нас барсан байна.*

*Аудитын илрүүлэлт:*

- *Байгууллага, хувь хүмүүсээс авах авлага болон хөрөнгийн урьдчилгаа зардлын тооцоог байгууллага, хувь хүмүүстэй тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй насжилт өндөртэй авлага бууруулж ажиллаагүй байна.*
- *Сум хөгжүүлэх сангаас 2016 оноос өмнө олгосон 79 иргэнтэй холбогдох 586199.5 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн авлага сангийн эргэцийг удаашруулж, хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна.*

### 3.5.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 1205676.8 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 1575423.9 мянган төгрөг болж 369747.1 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 3. Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Эм боох материал | 1,770.3 | 48,614.8 | 46,844.5 |
| Тусгай зориулалтын материал | 877.5 | | (877.5) |
| Бэлэн бүтээгдхүүн | 3,148.9 | 3,148.9 | - |
| Бичиг хэргийн материал | 10,191.4 | 12,248.1 | 2,056.7 |
| Аж ахуйн материал | 137,409.2 | 180,876.1 | 43,466.9 |
| Сэлбэг хэрэгсэл | 108,233.0 | 164,770.7 | 56,537.7 |
| Түлш, шатах тослох материал | 5,015.0 | 6,774.0 | 1,759.0 |
| Барилгын засварын материал | 2,126.3 | 8,013.5 | 5,887.2 |
| Хүнсний материал | 30,852.7 | 33,090.9 | 2,238.2 |
| Бусад хангамжийн материал | 906,052.5 | 1,117,886.9 | 211,834.4 |
| Дүн | 1,205,676.8 | 1,575,423.9 | 369,747.1 |

*Эх сурвалж: Жаргалант сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын бараа материалын үлдэгдэл 369747.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд эм, ариутгалын бодис болон ажилчдын нормын хувцас, хүнс нөөцөлж авсан байгаа нь нөлөөлж байна.

*Аудитын илрүүлэлт:*

- *Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 450 тоот "Хоолны зардлын норматив тогтоох тухай" тогтоолыг мөрдөж ажиллаагүй, хүүхдийн хоолны зарцуулалтад тавих хяналт сул*
- *Эм эмнэлгийн хэрэгслийн болон ариутгалын материалыг нийлүүлэхдээ тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжээс худалдан аваагүй, хувь хүнээс худалдан авсан байгаа нь хүүхдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эрсдэл үүсгэсэн*
- *Эд хариуцагчийн тооцоо хийж баримтаар баталгаажуулаагүй, шатахуун сэлбэг хэрэгсэл хяналтгүй зарцуулсан, нярвын тайлан гаргалт хангалтгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу байгаа зөрчлүүд голчлон харьяа байгууллагуудад илэрсэн байна.*

*Дээрх алдаа зөрчлийг төсвийн шууд захирагч нарын тайланд тусган шийдвэрлэснийг Төсвийн төвлөрүүлэн захирагч дотоод хяналт хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байна.*

### 3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 53139266.6 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 61356833.9 мянган төгрөг болж 8217567.3 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 4. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Барилга байгууламж, орон сууц | 41,325,823.4 | 48,422,416.2 | 7,096,592.8 |
| Тээврийн хэрэгсэл | 754,696.6 | 844,209.2 | 89,512.6 |
| Машин тоног төхөөрөмж | 2,874,166.2 | 3,211,065.1 | 336,898.9 |
| Тавилга эд хогшил | 1,880,783.4 | 2,315,809.7 | 435,026.3 |
| Түүх соёлын дурсгалт зүйл | 206,167.1 | 206,167.1 | - |
| Бусад үндсэн хөрөнгө | 1,975,464.8 | 2,206,443.7 | 230,978.9 |
| Номын фонд | 363,811.9 | 390,669.7 | 26,857.8 |
| Бусад хөрөнгө | 78,797.8 | 80,797.8 | 2,000.0 |
| Программ хангамж | 36,586.4 | 36,286.4 | (300.0) |
| Бусад биет бус хөрөнгө | 3,642,969.0 | 3,642,969.0 | - |
| Дүн | 53,139,266.6 | 61,356,833.9 | 8,217,567.3 |

*Эх сурвалж: Жаргалант сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 96932.1 мянган төгрөг, балансаас баланст шилжүүлэн авсан 2000.0 мянган төгрөг, үнэ төлбөргүй авсан 7359739.8 мянган төгрөг, хандиваар 863230.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн, 96638.9 мянган төгрөгийн хөрөнгө акталсан 7695.8 мянган төгрөгийн хөрөнгө балансаас баланст шилжүүлж 104334.8 мянган төгрөгөөр хөрөнгө хасагдсан байна.

*Аудитын илрүүлэлт:*

*- Засаг даргын Тамгын газар болон харьяа төсөвт байгууллагууд тайлант онд үндсэн хөрөнгийн бүртгэлд тавих хяналт сул, үнэ төлбөргүй авах хөрөнгийн орлогыг үр дүнд буруу тайлагнасан, засгийн газрын 10-р тогтоолын хэрэгжилт хангалтгүй, ТШЗ-ийн тайланд үнэ төлбөргүй хөрөнгө дутуу авсан, сургууль, цэцэрлэгүүдэд БСШУ-ны яам болон бусад хөрөнгө оруулалтаар ирж байгаа хөрөнгийн хүлээн авсан, хүлээлгэн өгсөн баримт бүртгэл хангалтгүй, хөрөнгөд тавих дотоод хяналт сул байгаа зөрчил давтагдан гарч байна.*

*Дээрх алдаа зөрчлийг төсвийн шууд захирагч нарын тайланд тусган шийдвэрлэснийг Төсвийн төвлөрүүлэн захирагч дотоод хяналт хэрэгжүүлэн хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хадгалалт, эзэмшилд анхаарал хандуулах шаардлагатай байна.*

### 3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 20179.9 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 37585.4 мянган төгрөг болж 17405.5 мянган төгрөгөөр өссөн байна.

| *Хүснэгт №.5. Нийт өр төлбөрийн үлдэгдэл* | | *|мянган төгрөг/* | |
|---|---|---|---|
| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өссөн+ Буурсан - |
| Ажилчидтай холбогдсон өглөг | 12,924.4 | 18,800.7 | 5,876.3 |
| Бараа үйлчилгээний өглөг | 38.1 | 2,018.0 | 1,979.9 |
| Хөрөнгө бэлтгэхтэй холбоотой | 320.0 | 4,807.8 | 4,487.8 |
| Байгууллагад төлөх өглөг | 6,897.4 | 11,958.9 | 5,061.5 |
| Нийт дүн | 20,179.9 | 37,585.4 | 17,405.5 |
| *Эх сурвалж: Жаргалант сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан* | | | |

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 18800.7 мянган төгрөгийн насжилт өндөртэй өр байна. Тайлант хугацаанд үүссэн өглөгийг барагдуулсан, жилийн эцсийн өглөгүүд дараа оны тайлангийн хугацаанд бүрэн барагдах боломжтой өглөгүүд байна.

### 3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 25722.3 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 26075615.6 мянган төгрөг болж 353319.0 мянган төгрөгөөр буурсан байна. Буурсан шалтгаан нь Өрхийн ЭМТ-ийн хөрөнгийг засгийн хөрөнгөөр шилжүүлэн бүртгэсэнтэй холбоотой байна.

| *Хүснэгт № 6. Засгийн газрын хувь оролцоо* | | *|мянган төгрөг/* | |
|---|---|---|---|
| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт/+/, бууралт /-/ |
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 25,722,296.6 | 26,075,615.6 | 353,319.0 |
| Засгийн газрын оруулсан капитал | | | - |
| Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/ | 353,318.3 | | (353,318.3) |
| Хуримтлагдсан үр дүн | 6,531,496.1 | 11,707,808.9 | 5,176,312.8 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 14,802,876.8 | 14,799,276.7 | (3,600.1) |
| Дүн | 47,409,987.8 | 52,582,701.2 | 5,172,713.4 |
| *Эх сурвалж: Жаргалант сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан* | | | |

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 14799276.7 мянган төгрөг болж 3600.1 мянган төгрөгөөр буурсан нь төсөвт байгууллагуудын дахин үнэлгээтэй хөрөнгө акталсантай холбоотой байна.

Хуримтлагдсан үр дүн 11707808.9 мянган төгрөг болж 5176312.8 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгө оруулалтаар бий болсон, дээд шатны байгууллагаас үнэ төлбөргүйгээр хүлээн авсантай холбоотой нэгтгэлд хамрагдсан байгууллагуудын хуримтлагдсан үр дүн нэмэгдсэнтэй холбоотой байна.

### 3.5.7 Орлогын данс

Орлого үр дүнгийн тайланд өмнөх оны үзүүлэлтээс 3290180.3 мянган төгрөгөөр өссөн байна. Тайлант оны орлогын үзүүлэлт 1496362.8 мянган төгрөгөөр үнэ төлбөргүй орлого өссөн, тусгай зориулалтын шилжүүлгийн орлого 1319128.8 мянган төгрөгөөр нэмэлт санхүүжилтийн орлого 474688.7 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой болно.

*Аудитын илрүүлэлт:*

*- Жаргалант ЗДТГ-т санхүүжилт илүү олгож төсөвт буцаан төвлөрүүлсэн, төрийн сангийн дотоод хяналт хангалттай хэрэгжүүлээгүй буцсан болон залруулсан гүйлгээ ихтэй, авлага, өглөг бууруулаагүй тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй,*

*-ТЗШ-ийн байгууллагууд үйл ажиллагааны орлого дутуу төвлөрүүлсэн, сумдын байцаагч нарын гүйцэтгэлийн ажлын тайлан хангалтгүй, мэдээлэл өгдөггүй, татварын орлогын төлөвлөлт гүйцэтгэлд тулгуурлаагүй, газрын төлбөрийн орлогын мэдээлэл хангалтгүй, төсвийн орлого бүрдүүлдэг хог хаягдлын хураамж, торгуулийн орлого байгалийн баялаг, ус рашаан ашигласны төлбөрийг бүрэн төвлөрүүлээгүй ажлын гүйцэтгэл хангалтгүй,*

*-Санхүүгийн тайлангийн үр дүн зөрүүтэй илэрхийлэгдсэн, тайлангийн үнэн зөв байдал хангалтгүй, хувийн цэцэрлэг, өрхийн эмнэлгүүдийн төсвөөс авч байгаа хөрөнгө оруулалт, ЭМД-ын санхүүжилт, ТЗШ-ийн санхүүжилтийн зарцуулалтад тавих сумын удирдлага болон санхүүгийн дотоод хяналт сул байна*

*-Сургууль, цэцэрлэгийн орчинд байрлаж байгаа Юнитель ХХК-ны сүлжээний антен байршуулсан түрээсийн төлбөрийн гэрээг шинэчлээгүй, цайны газар, спорт заалны түрээсийн орлогод тавих дотоод хяналт хангалтгүй,*

*Дээрх зарим алдаа зөрчлийг төсвийн шууд захирагч нарын тайланд тусган шийдвэрлэснийг Төсвийн төвлөрүүлэн захирагч дотоод хяналт хэрэгжүүлэн сүлжээний антены түрээсийн гэрээнд анхаарал хандуулж үр дүнтэй ажил зохион байгуулах төрийн өмчийн байр ашиглалтад анхаарал хандуулах шаардлагатай байна.*

### 3.5.8 Зардлын данс

Тайлант оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал өмнөх оноос 1357003.2 мянган төгрөгөөр өссөн байна. Төсөвт зардлаас тогтмол зардал 136481.4 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 21430.4 мянган төгрөгөөр, цалин хөлс нэмэгдэл урамшил 712093.5 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 486997.9 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

Зардлын данстай холбоотой 123066.6 мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бус, үрэлгэн зарцуулсан байна.

*Аудитын илрүүлэлт:*

- *ОНХС-ийн хөрөнгийг ном хэвлэл, төлөөлөгч хөтөлбөр, сэтгүүл, тэмцээн уралдаанд зориулалт бус зарцуулж журам зөрчсөн, хуулийн хэрэгжилт хангалтгүй, ТЗШ-ийн байгууллагаас бусад байгууллагын зардал санхүүжүүлсэн, сангийн хөрөнгийн үр дүнг бууруулж олон нийтийн эрх ашигт нийцсэн хөрөнгө оруулалт хийгдээгүй байна*
- *Харьяа төсөвт байгууллагуудад төсвийн зарцуулалттай холбоотой хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх зарчмыг хэрэгжүүлж ажиллаагүй анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, авлага өглөг тооцоо нийлж баталгаажуулаагүй, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар зарцуулах зарчмыг хэрэгжүүлээгүй,*
- *Үр дүнгийн урамшуулал ур чадвар тушаал шийдвэр ирээгүй байхад захирал эрхлэгч нарт урьдчилж олгодог, ажилчдын цалин, илүү цаг үр дүнг илүү дутуу бодож олгодог, зардал хооронд зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулдаг, е-баримтгүй гүйлгээ хийдэг зэрэг нийтлэг алдаа зөрчлүүд гарсан байна.*

*Дээрх зарим алдаа зөрчлийг төсвийн шууд захирагч нарын тайланд тусган шийдвэрлэснийг Төсвийн төвлөрүүлэн захирагч нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж дотоод хяналтыг хэрэгжүүлэн санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх шаардлагатай байна.*

### 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Жаргалант сумын ИТХ-ын 2020 оны орон нутгийн төсөв батлах тухай 10/02 дугаар тогтоолоор Жаргалант сумын Төвлөрүүлэн захирагчийн тайлант онд 1086390.4 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 1155789.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж төлөвлөгөөг 106.3 хувиар биелүүлсэн байна.

*Хүснэгт дугаар №7 Орлогын төлөвлөгөө гүйцэтгэл* *\/мянган төгрөгөөр/*

| д/д | Орлогын нэр төрөл | Татварын орлогын төлөвлөгөө | 2020.09.28/10/02 тоот тогтоолоор | Орлогын гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|---|
| Нийт орлогын дүн | | 1,093,790.4 | 1,086,390.4 | 1,155,789.2 | (69,398.8) |
| А | Нийт орлого тусламжийн дүн | 1,093,790.4 | 1,086,390.4 | 1,155,789.2 | (69,398.8) |
| Б | Нийт орлогын дүн | 1,093,790.4 | 1,086,390.4 | 1,155,789.2 | (69,398.8) |
| В | Суурь орлогын дүн | 1,093,790.4 | 1,086,390.4 | 1,155,789.2 | (69,398.8) |
| | Урсгал орлогын дүн | 33,000.0 | 33,000.0 | 12,510.5 | 20,489.5 |
| Г | Татварын орлого | 1,060,790.4 | 1,053,390.4 | 1,143,278.7 | (89,888.3) |
| 1 | Хувь хүний орлогын албан татвар | 892,753.0 | 892,753.0 | 1,012,545.8 | (119,792.8) |
| | Үйл ажиллагааны орлогын татвар | 114,903.0 | 114,903.0 | 155,470.6 | (40,567.6) |
| | Хөрөнгийн орлого | 565,200.0 | 565,200.0 | 561,550.8 | 3,649.2 |
| | ХХОАТ-ын бусад орлого | 212,650.0 | 212,650.0 | 295,524.4 | (82,874.4) |
| 2 | Өмчийн татвар | 6,346.4 | 6,346.4 | 6,009.0 | 337.4 |
| | Бууны албан татвар | 6,346.4 | 6,346.4 | 6,009.0 | 337.4 |
| 4 | Бусад орлого | 161,691.0 | 154,291.0 | 124,724.0 | 29,567.1 |
| | Улсын тэмдэгтийн хураамж | 35,672.0 | 35,672.0 | 50,189.4 | (14,517.4) |
| | Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 73,469.0 | 73,469.0 | 38,976.6 | 34,492.4 |
| | Ус рашааны нөөц ашигласны төлбөр | 5,350.0 | 5,350.0 | 342.3 | 5,007.7 |
| | Газрын төлбөр | 25,000.0 | 25,000.0 | 30,032.7 | (5,032.7) |
| | Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигла | 22,200.0 | 14,800.0 | 5,182.9 | 9,617.1 |
| Д | Татварын бус орлого | 33,000.0 | 33,000.0 | 12,510.5 | 20,489.5 |
| | Бусад орлого | 13,000.0 | 13,000.0 | 8,465.0 | 4,535.0 |
| : | Хүү торгуулийн орлого | 20,000.0 | 20,000.0 | 4,045.5 | 15,954.5 |
| | *Эх сурвалж: Жаргалант сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан* | | | | |

### 3.6.2 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 26250780.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 26250780.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрт зориулан 23157308.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 22692664.5 мянган төгрөгийг урсгал зардалд 262174.2 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд 202469.8 мянган төгрөгийг эргэж төлөгдөх зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 18497980.0 мянган төгрөгийг улсын төсвөөс 3972884.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 342547.0 мянган төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас, 312300.0 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлого, 31596.7 мянган

төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөж санхүүжилтийг бүрэн олгосон байна.

*Хүснэгт №8 Төсвийн гүйцэтгэл* *\/мянган төгрөгөөр/*

| Жаргалант сумын төсвийн төлөвлөгөө гүйцэтгэл | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Д/д | Байгууллагын нэр | Эхний үлдэгдэл | | Нийт төлөвлөгөө | | | | Гүйцэтгэл | | | Зөрүү | |
| | | С1 | С2 | 2020 оны төсөв | УАО | Өмнөх он | Нийт батлагдсан төсөв | Санхүүжилт | УАО | Нийт төсвийн гүйцэтгэл | Санхүүжилт | Орлого |
| 1 | ЗДТГ | | | 975,613.3 | 2,000.0 | | 977,613.3 | 948,160.4 | 879.5 | 949,039.9 | 27,452.9 | 1,120.5 |
| 2 | ИТХ | | | 129,900.0 | | | 129,900.0 | 128,516.0 | | 128,516.0 | 1,384.0 | - |
| 3 | ЗАА | | | 69,100.0 | | | 69,100.0 | 68,681.0 | | 68,681.0 | 419.0 | - |
| 4 | Хот тохижилт | | | 416,500.0 | | | 416,500.0 | 415,490.0 | | 415,490.0 | 1,010.0 | - |
| 5 | СХС | 2,469.8 | 15,013.8 | | 200,000.0 | 2,469.8 | 202,469.8 | | 132,736.1 | 132,736.1 | - | 67,263.9 |
| 6 | ОНХС | 29,126.9 | 32,845.7 | 233,047.3 | | 29,126.9 | 262,174.2 | 233,047.3 | 875.0 | 233,922.3 | - | (875.0) |
| 7 | ХХТсан | | | | | | - | | 657.2 | 657.2 | - | (657.2) |
| | ОНБ-дын дүн | 31,596.7 | 47,859.5 | 1,824,160.6 | 202,000.0 | 31,596.7 | 2,057,757.3 | 1,793,894.7 | 135,147.8 | 1,929,042.5 | 30,265.9 | 66,852.2 |
| 1 | ЕБС-1 | | | 2,547,810.5 | 4,000.0 | | 2,551,810.5 | 2,481,212.2 | 210.0 | 2,481,212.2 | 66,598.3 | 3,790.0 |
| 2 | ЕБС-2 | | | 1,678,651.0 | 800.0 | | 1,679,451.0 | 1,643,759.2 | 800.0 | 1,644,559.2 | 34,891.8 | - |
| 3 | ЕБС-3 | | | 1,595,664.8 | 1,600.0 | | 1,597,264.8 | 1,543,760.9 | 2,069.0 | 1,545,829.9 | 51,903.9 | (469.0) |
| 4 | ЕБС-4 | | | 1,778,556.4 | 600.0 | | 1,779,156.4 | 1,740,063.2 | 418.2 | 1,740,481.4 | 38,493.2 | 181.8 |
| 5 | ЕБС-5 | | | 1,408,813.7 | 102,100.0 | | 1,510,913.7 | 1,376,439.5 | 51,231.2 | 1,427,670.7 | 32,374.2 | 50,868.8 |
| 6 | ЕБС-6 | | | 1,859,954.5 | 600.0 | | 1,860,554.5 | 1,815,520.9 | 600.0 | 1,816,120.9 | 44,433.6 | - |
| 7 | ЕБС-7 | | | 1,765,727.2 | 600.0 | | 1,766,327.2 | 1,729,521.5 | 680.0 | 1,730,201.5 | 36,205.7 | (80.0) |
| 8 | НТБ | | | 105,773.0 | | | 105,773.0 | 105,773.0 | | 105,773.0 | - | - |
| 9 | СӨБ-1 | | | 413,269.8 | - | - | 413,269.8 | 396,901.0 | - | 396,901.0 | 16,368.8 | - |
| 10 | СӨБ-2 | | | 441,769.2 | | | 441,769.2 | 417,397.3 | | 417,397.3 | 24,371.9 | - |
| 11 | СӨБ-3 | | | 488,517.3 | | | 488,517.3 | 454,596.0 | | 454,596.0 | 33,921.3 | - |
| 12 | СӨБ-4 | | | 441,124.5 | | | 441,124.5 | 416,819.9 | | 416,819.9 | 24,304.6 | - |
| 13 | СӨБ-5 | | | 418,279.2 | | | 418,279.2 | 395,270.9 | | 395,270.9 | 23,008.3 | - |
| 14 | СӨБ-6 | | | 341,361.9 | | | 341,361.9 | 324,626.3 | | 324,626.3 | 16,735.6 | - |
| 15 | СӨБ-7 | | | 529,315.9 | | | 529,315.9 | 496,236.4 | | 496,236.4 | 33,079.5 | - |
| 16 | СӨБ-8 | | | 440,952.5 | | | 440,952.5 | 402,174.4 | | 402,174.4 | 38,778.1 | - |
| 17 | СӨБ-9 | | | 342,239.1 | | | 342,239.1 | 334,757.6 | | 334,757.6 | 7,481.5 | - |
| 18 | СӨБ-10 | | | 430,602.0 | | | 430,602.0 | 406,168.3 | | 406,168.3 | 24,433.7 | - |
| 19 | СӨБ-11 | | | 410,436.2 | | | 410,436.2 | 399,337.3 | | 399,337.3 | 11,098.9 | - |
| 20 | СӨБ-12 | | | 442,511.2 | | | 442,511.2 | 427,940.0 | | 427,940.0 | 14,571.2 | - |
| 21 | СӨБ-13 | | | 363,614.4 | | | 363,614.4 | 348,235.8 | | 348,235.8 | 15,378.6 | - |
| 22 | СӨБ-14 | | | 396,992.0 | | | 396,992.0 | 379,227.2 | | 379,227.2 | 17,764.8 | - |
| 23 | СӨБ-15 | | | 294,358.7 | | | 294,358.7 | 290,833.2 | | 290,833.2 | 3,525.5 | - |
| 24 | СӨБ-16 | | | 530,275.5 | | | 530,275.5 | 510,811.8 | | 510,811.8 | 19,463.7 | - |
| 25 | ХХ цэцэрлэг | | | 446,037.3 | | | 446,037.3 | 401,454.1 | | 401,454.1 | 44,583.2 | - |
| 26 | Лицей | | | 24,201.4 | | | 24,201.4 | 24,201.4 | | 24,201.4 | - | - |
| 27 | Өрх ЭМТ | | | 1,052,442.0 | | | 1,052,442.0 | 1,052,442.0 | | 1,052,442.0 | - | - |
| | ТЗШ дүн | | | 20,989,251.2 | 110,300.0 | - | 21,099,551.2 | 20,315,481.3 | 56,008.4 | 20,371,489.7 | 673,769.9 | 54,291.6 |
| | Нийт дүн | 31596.7 | 47859.5 | 22,813,411.8 | 312,300.0 | 31,596.7 | 23,157,308.5 | 22,109,376.0 | 191,156.2 | 22,300,532.2 | 704,035.8 | 121,143.8 |

*Эх сурвалж: Жаргалант сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Үндсэн үйл ажиллагааны орлого 112300.0 мянган төгрөг орохоос 58420.1 мянган төгрөгийн орлого орж батлагдсан төсвөөс 53879.9 мянган төгрөгөөр орлого дутуу бүрдүүлсэн байгаа нь цар тахалтай холбоотой сургууль цэцэрлэгийн үйл ажиллагаа зогссонтой холбоотой байна.Төсвөөс санхүүжих 22813411.8 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч 22109376.0 мянган төгрөгийг зарцуулж төсөвт 704035.8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Туслах үйл ажиллагааны орлого 132736.1 мянган төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 67263.9 мянган төгрөгөөр буурсан нь СХС-гийн зээлийн эргэн төлөлтөөс оруулах орлого биелээгүйтэй холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын 42 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэх 262174.2 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас 40 арга хэмжээний 229328.5 мянган төгрөгийн санхүүжилт олгож орон нутгийн хөгжлийн сангийн дансанд он дамжсан 2 арга хэмжээний 32845.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл нь 22109376.0 мянган төгрөг зарцуулагдаж нийт зардал 98.0 хувьтай байгаа нь хөрөнгийн зардалтай холбоотой байна.

### 3.6.3 Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт дансаар хандив тусламжийн орлогоор 13400.0 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн эрх шилжүүлэлтээр дээд шатны төсөв захирагчаас 1189844.7 мянган төгрөг, төсөв захирагчийн хуваарилсан хөрөнгөөр 37793.3 мянган төгрөг, өөрийн үйл ажиллагааны орлогоос 26232.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

*Хүснэгт №.9. Нэмэлт данс* *\/мянган төгрөг/*

| | Нийт орлого | | Зориулалт |
|---|---|---|---|
| 1 | Хандив тусламж | 13,400.0 | Төсөл хөтөлбөр болон бусад үйл ажиллагаанаас бий болсон хөрөнгө |
| 2 | Үйл ажиллагааны орлого | 26,232.8 | Төсөвт байгууллагын хүрээнд бий болсон үндсэн үйл ажиллагааны орлого |
| 3 | Дээд шатны төсөвт тусгагдсан | 1,189,844.7 | ОНХС, ОНХО болон бусад хөрөнгө оруулалтаар эрх шилжүүлсэн нэмэлт орлого |
| 4 | Дээд шатны төсвөөс хуваарласан | 37,793.3 | ОНХС хөрөнгө оруулалт, хүн амын тооллогын зардал, бэлчээр ашиглалтын хөрөнгө оруулалт |
| | **Нийт дүн** | **1,267,270.8** | |

*Эх сурвалж: Жаргалант сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Үүнээс гэрээт ажлын хөлсөнд 45000.0 мянган төгрөг, бараа материалын зардалд 16713,7 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 117805.7 мянган төгрөг, бусад бараа үйлчилгээний зардалд 111923.7 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 911667.6 мянган төгрөг зарцуулж 64160.0 мянган төгрөг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

### 3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 158 мэдээллээс 9 мэдээлэл хугацаа хоцроож 149 мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

### 3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид төсөвт буцаан төвлөрүүлэх 1375.8 мянган төгрөгийн 1акт, авлага бууруулах 141100.1 мянган төгрөгийн 1 албан шаардлага, зээлийн авлага бууруулах, анхан шатны баримт бүрдүүлэх

995355.6 мянган төгрөгийн 3 алдаа зөрчилд зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт 48% хэрэгжсэн байна.

*Хүснэгт 10* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тоо | дүн | тоо | дүн | тоо | дүн | |
| Акт | 1 | 1,375.8 | | | 1 | 1,375.8 | 0% |
| Албан шаардлага | 1 | 141,100.1 | 1 | 141,100.1 | | | 100% |
| Зөвлөмж | 3 | 995,355.6 | 2 | 409,154.1 | 1 | 586,201.5 | 41.2% |
| Нийт дүн | 5 | 1,137,831.5 | 3 | 550,254.2 | 2 | 587,577.3 | 48.4% |
| *Эх сурвалж: Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудит* | | | | | | | |

Өмнөх онд өгсөн төлсөн төлбөрийн акт барагдуулаагүй, албан шаардлагын биелэлт хэрэгжүүлсэн, СХС-ийн авлага бууруулах зөвлөмж бүрэн хэрэгжээгүй байна.

## 3.9 АУДИТЫН ЯВЦАД ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 27 төсвийн байгууллага, 5 Өрхийн эмнэлэг, 12 хувийн цэцэрлэг, 1 Лицей сургууль нийт 45 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 25 байгууллагыг аудитад хамруулан дүгнэлт гаргаж, 2 тайланг түүвэрт хамруулж бусад 18 байгууллага хувийн аудитын газраар үйлчлүүлсэн байна.

*Хүснэгт №11. Аудитад хамрагдсан хэлбэр, аудитын дүгнэлт*

| № | Байгууллагын ангилал, нэр | | Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр | | | Аудитын дүгнэлт | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Санал дүгнэлт гаргасан | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Түүвэрт | Санал дүгнэлт гаргаагүй |
| 1 | Төсвийн шууд захирагч | ИТХ | - | | | | 1 | |
| 2 | | ЗДТГ | 1 | | 1 | | | |
| 3 | | Хот тохижилт | 1 | 1 | | | | |
| 4 | | ЕБСургууль-1 | 1 | 1 | | | | |
| 5 | | ЕБСургууль-2 | - | | | | 1 | |
| 6 | | ЕБСургууль-3 | 1 | 1 | | | | |
| 7 | | ЕБСургууль-4 | 1 | 1 | | | | |
| 8 | | ЕБСургууль-5 | 1 | 1 | | | | |
| 9 | | ЕБСургууль-6 | 1 | 1 | | | | |
| 10 | | ЕБСургууль-7 | 1 | 1 | | | | |
| 11 | | НТБоловсрол | 1 | 1 | | | | |
| 12 | | СӨБ-Цэцэрлэг 1 | 1 | 1 | | | | |
| 13 | | СӨБ-Цэцэрлэг 2 | 1 | 1 | | | | |
| 14 | | СӨБ-Цэцэрлэг 3 | 1 | 1 | | | | |
| 15 | | СӨБ-Цэцэрлэг 4 | 1 | 1 | | | | |
| 16 | | СӨБ-Цэцэрлэг 5 | 1 | 1 | | | | |
| 17 | | СӨБ-Цэцэрлэг 6 | 1 | 1 | | | | |
| 18 | | СӨБ-Цэцэрлэг 7 | 1 | 1 | | | | |
| 19 | | СӨБ-Цэцэрлэг 8 | 1 | 1 | | | | |
| 20 | | СӨБ-Цэцэрлэг 9 | 1 | 1 | | | | |
| 21 | | СӨБ-Цэцэрлэг 10 | 1 | 1 | | | | |
| 22 | | СӨБ-Цэцэрлэг 11 | 1 | 1 | | | | |
| 23 | | СӨБ-Цэцэрлэг 12 | 1 | 1 | | | | |
| 24 | | СӨБ-Цэцэрлэг 13 | 1 | 1 | | | | |
| 25 | | СӨБ-Цэцэрлэг 14 | 1 | 1 | | | | |
| 26 | | СӨБ-Цэцэрлэг 15 | 1 | 1 | | | | |
| 27 | | СӨБ-Цэцэрлэг 16 | 1 | 1 | | | | |
| | **Дүн** | | **25** | **24** | **1** | **0** | **2** | **0** |

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”-24, “Хязгаарлалттай”-1 нийт 25 дүгнэлт гаргасан байна.

***<u>Санхүүгийн нэгтгэсэн тайлангаар илэрсэн алдаа, зөрчил:</u>***

Аудитаар нийт 1217458.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 709266.1 мянган төгрөгийн алдааг арилгах 1 албан шаардлага, 508192.4 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, хөрөнгө шийдвэрлэх 3 зөвлөмж өглөө.

*<u>Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга</u>*

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулга хийгдээгүй болно.

***<u>Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн албан шаардлага:</u>***

Аудитаар дараах 709266.1 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчилд албан шаардлага тогтоож хүргүүллээ. Үүнд:

***1. ОНХС-ийн зарцуулалт***

1.1. *<u>Илрүүлэлт:</u>ОНХС-ийн хөрөнгөөс хүлээн авалтын зардал гарган зориулалт бус зарцуулж журам зөрчсөн, хуулийн хэрэгжилт хангалтгүй, төсвийн хөрөнгийн үр ашгийг бууруулсан 4252.9 мянган төгрөгийн зөрчил дутагдал илэрлээ.*

1.2. *Илрүүлэлт: ОНХС-ийн хөрөнгийг ном хэвлэл, төлөөлөгч хөтөлбөр, сэтгүүл, тэмцээн уралдаанд зориулалт бус зарцуулж журам зөрчсөн, хуулийн хэрэгжилт хангалтгүй, ТЗШ-ийн байгууллагаас бусад байгууллагын зардал санхүүжүүлсэн, сангийн хөрөнгийн үр дүнг бууруулж олон нийтийн эрх ашигт нийцсэн хөрөнгө оруулалт хийгдээгүй 118.8 сая төгрөгийн зөрчил илэрлээ.*

*Энэ нь Төрийн Төсвийн тухай хуулийн 16-р зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 6-р зүйлийн 6.4.2-д "төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх", ОНХС-ийн 228-р журмын 4-р зүйлийн 4.2.4-д "аливаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд олгох буцалтгүй тусламж, дэмжлэг, тэтгэмж, урамшуулал"-д зарцуулахыг хориглоно" гэсэн хуулийн заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн, үнэн зөв, байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.*

1.3. *Шийдвэрлэсэн нь: Сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байгаа 4252.9 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлэх*

***2. СХС-ийн зарцуулалт***

2.1. *Илрүүлэлт: СХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс насжилт өндөртэй авлага бууraaгүй, хийж хэрэгжүүлсэн ажил хангалтгүй, зориулалтын дагуу ашиглахгүй байгаа зээлтэй, зээлийн эргэлт удаашралтай, иргэдэд хүртэх хүртээмж бага байгаа 586.2 сая төгрөгийн зөрчил илэрлээ.*

*Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянаж ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн, үнэн зөв, байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.*

2.2. *<u>Шийдвэрлэсэн нь:</u> Зээлийн эргэн төлөлтийн үр дүнг дээшлүүлж төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, сангийн хөрөнгийг зориулалт бус зарцуулахгүй байх албан шаардлага бичих*

Төвлөрүүлсэн захирагчид 508192.4 мянган төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 3 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

## ***<u>Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн алдаа, зөрчил</u>***

Жаргалант сумын ТТЗ-ын нэгтгэлд хамрагдсан төсвийн шууд захирагчдын 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт  мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч 133856.0 мянган төгрөгийн 25 алдааг залруулсан байна.

Залруулагдаагүй 2030630.7 мянган төгрөгийн алдаа зөрчлөөс 5750.0 мянган төгрөгийн 8 алдаа зөрчилд 8 төлбөрийн акт, 183796.4 мянган төгрөгийн 2 алдаа зөрчилд 2 албан шаардлага, 1707140.8 мянган төгрөгийн 69 алдаа зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна. Нийт алдаа зөрчил, шийдвэрлэлтийг хүснэгтээр харуулбал:

*Хүснэгт № 12. ТШЗ-ын нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн нийт алдаа зөрчил, шийдвэрлэлт /мянган.төгрөг/*

| № | Байгууллагын нэр | нийт илэрсэн алдаа зөрчил | | Үүнээс залруулсан | | Залруулаагүй алдаа, зөрчил | | Үүнээс: Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | тоо | дүн | тоо | дүн | тоо | дүн | тоо | дүн | тоо | дүн | тоо | дүн |
| 1 | ЗДТГ | 5 | 1,572,442.8 | 1 | 35,833.7 | 4 | 1,536,609 | 1 | 1,368.0 | 1 | 183,796.4 | 2 | 1,351,444.7 |
| 2 | Хот тохижилт | 4 | 10,834.9 | 2 | 802.8 | 2 | 10,032 | | | | | 2 | 10,032.1 |
| 3 | ЕБСургууль-1 | 5 | 10,492.0 | 1 | 828.9 | 4 | 9,663 | 1 | 1,373.1 | | | 3 | 8,290.0 |
| 4 | ЕБСургууль-3 | 3 | 45,441.0 | 1 | 519.0 | 2 | 44,922 | | | | | 2 | 44,922.0 |
| 5 | ЕБСургууль-4 | 3 | 82,032.1 | | | 3 | 82,032 | | | | | 3 | 82,032.1 |
| 6 | ЕБСургууль-5 | 5 | 4,300.6 | 3 | 4,300.6 | 2 | - | | | | | 2 | |
| 7 | ЕБСургууль-6 | 6 | 36,340.7 | 3 | 3,466.3 | 3 | 32,874 | | | | | 3 | 32,874.4 |
| 8 | ЕБСургууль-7 | 3 | 72,960.8 | | | 3 | 72,961 | | | 1 | | 2 | 72,960.8 |
| 9 | НТБоловсрол | 2 | - | | | 2 | - | | | | | 2 | |
| 10 | СӨБ-1 | 4 | 7,870.1 | | | 4 | 7,870 | | | | | 4 | 7,870.1 |
| 11 | СӨБ-2 | 9 | 6,230.4 | 4 | 5,508.9 | 5 | 722 | 2 | 721.5 | | | 3 | |
| 12 | СӨБ-3 | 6 | 6,856.9 | 2 | 2,671.1 | 4 | 4,186 | 1 | 360.8 | | | 3 | 3,825.0 |
| 13 | СӨБ-4 | 3 | 7,823.7 | | | 3 | 7,824 | | | | | 3 | 7,823.7 |
| 14 | СӨБ-5 | 5 | 8,610.7 | 2 | 7,375.0 | 3 | 1,236 | | | | | 3 | 1,235.7 |
| 15 | СӨБ-6 | 3 | 18,810.0 | 1 | 16,735.0 | 2 | 2,075 | | | | | 2 | 2,075.0 |
| 16 | СӨБ-7 | 4 | 40,130.9 | 1 | 33,079.5 | 3 | 7,051 | | | | | 3 | 7,051.4 |
| 17 | СӨБ-8 | 4 | 18,680.5 | | | 4 | 18,681 | | | | | 4 | 18,680.5 |
| 18 | СӨБ-9 | 5 | 8,409.9 | 1 | 87.5 | 4 | 8,322 | | | | | 4 | 8,322.4 |
| 19 | СӨБ-10 | 3 | 8,260.9 | | | 3 | 8,261 | 1 | 543.6 | | | 2 | 7,717.3 |
| 20 | СӨБ-11 | 4 | 5,162.6 | | | 4 | 5,163 | | | | | 4 | 5,162.6 |
| 21 | СӨБ-12 | 2 | - | | | 2 | - | | | | | 2 | |
| 22 | СӨБ-13 | 3 | 6,698.6 | | | 3 | 6,699 | | | | | 3 | 6,698.6 |
| 23 | СӨБ-14 | 7 | 36,227.6 | 3 | 21,534.8 | 4 | 14,693 | 1 | 691.3 | | | 3 | 14,001.5 |
| 24 | СӨБ-15 | 4 | 8,410.9 | 1 | 1,200.4 | 3 | 7,211 | 1 | 691.7 | | | 2 | 6,518.8 |
| 25 | СӨБ-16 | 3 | 7,602.1 | | | 3 | 7,602 | | | | | 3 | 7,602.1 |
| | **Дүн** | **105** | **2,030,630.7** | **26** | **133,943.5** | **79** | **1,896,687.2** | **8** | **5,750.0** | **2** | **183,796.4** | **69** | **1,707,140.8** |

## 3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар  авч үзэх асуудал хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа хөрөнгө үзэх шаардлагатай гэж үзлээ.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд 508192.4 мянган төгрөгийн зөрчлийг цаашид анхаарвал зохих асуудлын тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### 1. *Дотоод хяналттай холбоотой асуудал*

*1.1. Илрүүлэлт: ЗДТГ-т санхүүжилт илүү олгосон, төрийн сангийн дотоод хяналт хангалттай хэрэгжүүлээгүй 2000.0 мянган төгрөг, үйл ажиллагааны орлого дутуу төвлөрүүлсэн, сумдын байцаагч нарын гүйцэтгэлийн ажлын тайлан хангалтгүй, мэдээлэл өгдөггүй, татварын орлогын төлөвлөлт гүйцэтгэлд тулгуурлаагүй, газрын төлбөрийн орлогын мэдээлэл хангалтгүй, бүртгэл тооцоо судалгаа ирүүлээгүй 106738.3 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.*

*1.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах, төсвийн орлого бүрдэхгүй байх, дотоод хяналт хэрэгжихгүй байх*

*1.3.Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 41-р зүйлийн 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17-р зүйлийн 17.1.2-д "холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, хянах" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах, байцаагч нарын ажлын үр дүнг дээшлүүлэх, төсвийн орлого бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах*

*1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:Хүлээн зөвшөөрсөн*

### 2. *Төсвийн санхүүжилтэд тавих хяналттай холбоотой*

*2.1.Илрүүлэлт: Санхүүгийн тайлангийн үр дүн зөрүүтэй илэрхийлэгдсэн, тайлангийн үнэн зөв байдал хангалтгүй, хувийн цэцэрлэг, өрхийн эмнэлгүүд төсвөөс хөрөнгө оруулалт, ТЗШ-ийн санхүүжилт авч байгаа бөгөөд зарцуулалтад тавих сумын санхүүгийн албаны дотоод хяналт сул байгаа 401454.1 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.*

*2.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгийн үр дүн буурах, бусдад тэгш байдлыг олгохгүй байх, холбогдох хууль дүрэм журам хэрэгжихгүй байх.*

*2.3 Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 311 дүгээр тогтоолын 1.5-д “энэ журмын 1.4-т зааснаас бусад тохиолдолд “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ыг тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө”, 3.5-д “дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь хяналтын ажлын дүн, авсан арга хэмжээний талаар улирлад 1 доошгүй удаа тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын хурлаар хэлэлцүүлж, шаардлагатай бол шийдвэр гаргуулан хамт олонд мэдээлнэ”, 3.6-д ”дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэнэ” гэсэн заалтуудыг мөрдөж ажиллах,*

*2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:Үйлчлүүлэгч байгууллага хүлээн зөвшөөрсөн*

### 3. *Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал*

*3.1. Илрүүлэлт:Үндсэн хөрөнгийн бүртгэлд тавих хяналт сул, үнэ төлбөргүй авах хөрөнгийн орлогыг үр дүнд буруу тайлагнасан, засгийн газрын 10-р тогтоолын хэрэгжилт хангалтгүй, төсвийн харьяа байгууллагууд санхүүгийн тайланд хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн үнэ төлбөргүй хөрөнгө орлого дутуу авсан, харьяа төсөвт байгууллагуудын хөрөнгийн бүртгэл тооцоо хангалтгүй байгаа зөрчил илэрлээ.*

*3.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгийн үр дүн буурах, төсвийн хөрөнгө эзэнгүйдэх, хяналт буурах, дотоод хяналт хэрэгжихгүй байх*

*3.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллах, Засгийн газрын 10-р тогтоолын хэрэгжүүлэх, хөрөнгийн бүртгэлд тавих дотоод хяналтыг сайжруулах, орлого аваагүй хөрөнгийн асуудал шийдвэрлэх*

*3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:Үйлчлүүлэгч байгууллага хүлээн зөвшөөрсөн*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 6 дугаар сарын 20-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Хавсралт

## 5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо: | Аудитын нэр: | Жаргалант сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан | Аудитын код: |
|---|---|---|---|
| 2020 | | | ХОА-2021/17/СТА- |

| Шалгагдсан байгууллагын нэр: | Жаргалант сумын Засаг дарга | Мянган төгрөгөөр |
|---|---|---|

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| 1 | *Зээлийн эргэн төлөлт хангалтгүй, анхан шатны баримт дутуу, гарын үсгээр баталгаажуулаагүй зээл олгосон, ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт хангалтгүй, зориулалт бус зарцуулсан* | *709266.1* | *Албан шаардлага* | *Засаг дарга, Санхүү албаны дарга, Нягтлан бодогч* | *Ц.Цогтбаяр О.Сэрчмаа, Ц.Өсөхбаяр Н.Балт* |
| 2 | *Үйл ажиллагааны орлого дутуу төвлөрүүлсэн, сумдын байцаагч нарын гүйцэтгэлийн ажлын тайлан хангалтгүй, мэдээлэл өгдөөгүй, татварын орлогын төлөвлөлт гүйцэтгэлд тулгуурлаагүй, газрын төлбөрийн орлогын мэдээлэл хангалтгүй,* | *106738.3* | *Зөвлөмж* | *Засаг дарга, Санхүү албаны дарга, Нягтлан бодогч* | *Ц.Цогтбаяр О.Сэрчмаа,* |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | *бүртгэл тооцоо судалгаа ирүүлээгүй* | | | | |
| 3 | *Үндсэн хөрөнгийн бүртгэлд тавих хяналт сул, үнэ төлбөргүй авах хөрөнгийн орлогыг үр дүнд буруу тайлагнасан, засгийн газрын 10-р тогтоолын хэрэгжилт хангалтгүй, ТШЗ-ийн тайланд үнэ төлбөргүй хөрөнгө дутуу авсан, хөрөнгийн бүртгэл хангалтгүй* | *0* | *Зөвлөмж* | *Засаг дарга, Санхүү албаны дарга, Нягтлан бодогч* | *Ц.Цогтбаяр О.Сэрчмаа, Ц.Өсөхбаяр Н.Балт* |
| 4 | *Санхүүгийн тайлангийн үр дүн зөрүүтэй илэрхийлэгдсэн, тайлангийн үнэн зөв байдал хангалтгүй, хувийн цэцэрлэг, өрхийн эмнэлгүүд төсвөөс хөрөнгө оруулалт, ЭМД-ын санхүүжилт, ТЗШ-ийн санхүүжилт авч байгаа бөгөөд зарцуулалтанд тавих сумын санхүүгийн албаны дотоод хяналт сул байна.* | *401454.1* | *Зөвлөмж* | *Засаг дарга, Санхүү албаны дарга, Нягтлан бодогч* | *Ц.Цогтбаяр О.Сэрчмаа,* |
| | **Дүн** | ***1217458.5*** | | | |

ХОВД АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР